



БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТҮЛД ЮУ ХИЙЖ БОЛОХ ВЭ ХУРААНГУЙ

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ НЬ ХҮН БҮРТ ЭРХИЙГ НЬ ЭДЛҮҮЛЭХИЙН
ТӨЛӨӨ ХҮМҮҮСИЙН ХҮНЛЭГ СЭТГЭЛД ТУЛГУУРЛАН КАМПАНИТ
АЖИЛ ӨРНҮҮЛДЭГ 10 САЯ ХҮНИЙГ ЭГНЭЭНДЭЭ НЭГТГЭСЭН ДЭЛХИЙ
ДАЯАРХ ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫН ХӨДӨЛГӨӨН ЮМ.**

**ЭРХ БАРИГЧИД ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХЭМ ХЭМЖЭЭГ
ХҮНДЭТГЭДЭГ, ХАРИУЦЛАГАА ХҮЛЭЭДЭГ, АМЛАЛТДАА ХҮРДЭГ
ДЭЛХИЙ ЕРТӨНЦИЙГ БИЙ БОЛГОХЫН ТӨЛӨӨ БИД АЖИЛЛАДАГ.
БИД АЛИВАА ЗАСГИЙН ГАЗАР, УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ СУРТАЛ, ЭДИЙН
ЗАСГИЙН АШИГ СОНИРХОЛ, ШАШИН ШҮТЛЭГЭЭС АНГИД БИЕ
ДААСАН, ХАРААТ БҮС БӨГӨӨД ГИШҮҮД ДЭМЖИГЧДИЙНХЭЭ ХАНДИВ
ТУСЛАМЖААР САНХҮҮЖДЭГ. ХҮМҮҮС ЭВ САНААНЫ НЭГДЭЛТЭЙ,
ХҮМҮҮНЛЭГ ЭНЭРЭНГҮЙ БАЙСНААР ИЛҮҮ САЙХАН НИЙГМИЙГ БИЙ
БОЛГОЖ, ӨӨРЧИЛЖ ЧАДНА ГЭДЭГТ БИД ИТГЭДЭГ.**

©Эмнести Интернэшнл 2021 он

энэ товхимол дахь контент нь Креатив Коммонс-оор
зөвшөөрөгдсөн (жинхэнэ эх хувь, худалдааны бус, хуулбарлаагүй,
олон улсын 4.0) лицензийн дагуу баталгаажуулсан болно.
<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл манай: www.amnesty.org
цахим хуудасны зөвшөөрөл хэсгээр зочлоорой.

Их Британид, Лондоны нэгдүгээр Истон гудамж WC1X 0DW, Петр
Бененсон Хаус, Эмнести Интернэшнлийн байр, анхны хэвлэл,
2021 он.

Индекс: POL 30/41 10/2021

Эх хэл: Англи хэл

amnesty.org



Нүүр зураг: Жагсагчид 2019 оны 09 дүгээр сарын 20-нд
Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг өдөр иргэд
Өмнөд Африкийн Йоханнесбургт жагсаалын үеэр дуулж
буй нь. Зургийг Майкл Спатари/Эй Эл

УИ.МН
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БОЛ ХҮНИЙ ЭРХИЙН ХЯМРАЛ МӨН	4
ХҮНИЙ ЭРХ УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ЧУХАЛ	6
ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ ҮҮСГЭЖ БҮЙ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ЗОГСООХЫН ТӨЛӨӨ ДОРВИТОЙ АЛХАМ ХИЙСЭНГҮЙ	7
ЧИНЭЭЛЭГ УЛС ОРНУУД ДОТООДДОО БОЛОН ГАДААДАД Ч ХУРДАН ШУУРХАЙ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЁСТОЙ	8
МАЛТМАЛ ТҮЛШ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХАД СӨРӨГ НӨЛӨӨТЭЙ	10
ЗӨВХӨН ХҮЛЭМЖИЙН ХИЙГ ТЭГЛЭХ БУС, ЭНЭ ЯВЦДАА Ч ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧЛИЙГ ТЭГЛЭХ НЬ ЧУХАЛ	11
УЛС ОРНУУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ	13
ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ НЭН ДАРУЙ ЗОГСООЖ ХҮМҮҮСИЙГ ХАМГААЛ	13
УУР АМЬСГАЛЫН НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН ХҮМҮҮСТ ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХОД НЬ ТУСЛАХ	15
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХҮМҮҮСИЙН ЭРХЭД НИЙЦСЭН БАЙДЛЫГ ХАНГАХ	15
ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ, ОРОЛЦОХ, ШҮҮХЭЭР ХАМГААЛУУЛАХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛ	16
НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН ХҮМҮҮСИЙН ЭРХИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ, АЛДАГДАЛ, ХОХИРЛЫГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ	17
ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТУСЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ	18
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨӨС ҮҮДЭН ШИЛЖИН НҮҮСЭН, НҮҮХ ЭРСДЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ НЬ	18
АЮУЛГҮЙ, ЦЭВЭР, ЭРҮҮЛ ТОГТВОРТОЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ НЬ	20
БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ НЬ	20
КОРПОРЦИУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ	21

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТҮЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ ХУРААНГУЙ

Эмнести Интернэшнл

ХУРААНГУЙ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БОЛ ХҮНИЙ ЭРХИЙН ХЯМРАЛ МӨН

Уур амьсгалын аюултай байдал нь өмнө байгаагүйгээр өргөн хүрээнд хүний эрхийн зөрчил үүсгэж байна. Уур амьсгалын өөрчлөлт нь одоогийн болон ирээдүй хойчийн иргэний болон улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрхэд заналхийлж байна. Улс орон, нийгмийн бүлэгт нөлөөлөх уур амьсгалын өөрчлөлтийн шууд бус нөлөөлөл нь хүний эрх чөлөөнд заналхийлж, нэр төртэй амьдрах эрхийг зөрчиж, бүхий л ард түмний соёлын оршихуйд аюул учруулж болзошгүй байна.

Дэлхийн дулаарлын өнөөгийн түвшин аж үйлдвэржилтээс өмнөх үеийн цаг агаарын төлвөөс өдгөө даруй 1.1°C-ээр дээгүүр болсон нь хэдийн хэт халалт, урьд үзэгдээгүй ой хээрийн түймэр, шуурга, ган гачгийн хохирол учруулах болов. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас далайн төвшин аажмаар нэмэгдэх болсон нь олон сая хүний амьд явах, эрүүл байх, хоол хүнс, ундны ус, орон байр, ариун цэврийн байгууламж, шаардлагад нийцсэн амьдрах нөхцөлөөр хангагдах, ажиллах, хөгжих, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, соёл боловсрол олох, өөрийгөө тодорхойлох эрх, хүнлэг бусаар нэр төрийг гутаан доромжлон харьцахаас ангид байх зэрэг бусад эрхүүдэд ч ноцтой нөлөөлөх шалтгаан болж байна. Энэхүү товхимолд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн хүмүүсийн дээр дурдсан эрхүүд хэрхэн зөрчигдөж байгааг болон ирээдүйд ямар аюул, заналхийлэл учирч болох тухай өгүүлэх юм. Жишээ нь: 2013 онд Филиппиний Хайяан хар шуурганд 6300 гаруй хүн өртөж нас барсан бөгөөд 2019 онд Мозамбик, Малави, Зимбабвед болсон хар салхины улмаас ойролцоогоор 4 сая хүн нэрвэгдэж, зарим нь амь насаа алдаж, зарим нь эмнэлэг, ариун цэврийн байгууламж, сургуулийн



Зураг: Тосгоны оршин суугчид ширгэсэн голын голдрилыг ширтэж буй нь. Бангладеш, Сатхира, 2015 он.

Бангладеш нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртсөн эх газрын улсуудын нэг юм. Далайн төвшний нэмэгдэл, халуун орны хүй салхи, голын эргийн элэгдэл, үер, хөрсний нуралт, ган гачиг зэрэг хүчин зүйлс тухайн улсын ард түмэнд аюул учруулсаар байна.

Зургийг © Гетти Имэйжс, Баркрофт Медиагаас.

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!
ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТҮЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ
ХУРААНГУЙ

үйлчилгээг авах боломжгүй болж байв. Дотоодын нүүн шилжилтийг хянах төвийн мэдээлснээр 2008-2018 онд жил бүр дунджаар 20.88 сая хүн цаг ууртай холбоотой гамшиг, сүйрлийн улмаас дотооддоо нүүн шилжихээс аргагүй болсон гэжээ.

Манай гараг, хүн төрөлхтний хувьд цаг агаарын дундаж температур өссөөр байх нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг эрчимжүүлнэ. Тухайлбал, Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагын тооцоолсноор уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн 2030-2050 оны хооронд жил бүр 250 мянган хүн хумхаа, хүнс тэжээлийн дутагдал, суулгалт болон дулааны стрессээс үүдэн нас барах магадлалтай байна. Дэлхийн Хүнсний Хөтөлбөрийн тооцоолж буйгаар уур амьсгалын өөрчлөлт нь 2050 он гэхэд дэлхий дээрх өлсгөлөн, хүнс тэжээлийн хомсдолыг 20%-иар нэмэгдүүлэх магадлалтай аж. Дэлхийн температур 2°C-ээр нэмэгдвэл 1 тэрбумаас илүү хүн усны нэн их хомсдолд орж болзошгүй.

Эрдэмтдийн баталснаар дэлхийн дулаарлыг 1.5°C-д барих нь чухал. Уур Амьсгалын Өөрчлөлтийн тухай Засгийн Газар хоорондын Мэргэжилтнүүдийн хороо (УАӨТЗГХМХ) дэлхийн дундаж температурын өсөлтийг 2°C-д хүргэлгүй 1.5°C-д барихад хэт халалтад өртөх магадлалтай хүмүүсийн тоо 420 саяас бага байх, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн усны стресст өртдөг хүмүүсийн тоог 50%-иар багасгаж, хөгжиж буй жижиг арлын орнуудыг эргийн үерт автах эрсдэлээс 80% хүртэл бууруулах боломжтой гэж тооцоолжээ. Дэлхийн дундаж температурыг 1.5°C-ээс хэтрүүлэлгүй барихын тулд яаралтай, олон төрлийн арга хэмжээ авахгүй бол хариу арга хэмжээ авах боломжууд хумигдсаар байх төлөвтэй байгаа юм. Нүүрстөрөгчийн ялгаруулалтыг тэг түвшинд хүртэл бууруулвал дэлхийн одоогийн дундаж температураас болж үүсээд буй хүний эрхэд нөлөөлж болохуйц аюултай нөлөөлөл багасна. Ингэхийн тулд цаашид улс орнууд дэлхийн дундаж температурыг доод түвшинд барих хэрэгтэй болно.

Уур амьсгалын хямрал бол удаан тогтсон шударга бус байдлын илрэл юм. Хэдийгээр уур амьсгалын өөрчлөлт нь хүн бүрд нөлөөлж буй дэлхийн асуудал боловч энэ нь нөөц баялаг, эрх мэдлийг шударга бус хуваарилдаг төрийн бодлого, хуучирсан арга хэлбэрүүд, бүтцийн тэгш бус байдлаас орхигдож, ялгаварлан гадуурхалд өртсөн хувь хүмүүс, бүлгүүдэд харьцангуй хүчтэй нөлөөлдөг. Тухайлбал, эмэгтэйчүүдийн ажил үүрэг нь ихэвчлэн байгалийн нөөцөөс хамааралтай хязгаарлагдмал байх нь элбэг бөгөөд ингэснээр уур амьсгалын нөлөөлөлд илүү өртөмтгий болдог. Уугуул иргэд амьдрал ахуй, орон байр, анагаах ухаан болон соёлын онцлогийн хувьд хүрээлэн буй байгаль орчинтойгоо харилцан шүтэлцээтэй амьдардаг бөгөөд тэд ихэвчлэн гамшигт өртөмтгий газар нутагт аж төрдөг. Түүхээс харвал энэ нь ихэвчлэн тэднийг өмчөө хураалгах, албадан нүүлгэлтэд өртүүлдэг байсан. Иймээс тэд уур амьсгалын нөлөөлөлд хамгийн их өртөж буй бүлгүүдийн нэг болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд энгийн иргэдтэй харьцуулахад илүү их эрсдэлд байдаг бөгөөд гамшигийн эрсдэлийг бууруулах бодлогод дуу хоолой нь орхигдсоор байна. Энэхүү товхимолд хүйс, анги давхарга, цөөнхийн статус, хөгжлийн бэрхшээл, нас болон нүүн шилжсэн байдал зэргээсээ болж орхигдсон тэдгээр бүлэгт уур амьсгалын өөрчлөлт хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох юм.

Хөгжиж буй улсууд ялангуяа, нам дор жижиг арлын улсууд болон хөгжил буурай орны иргэд уур амьсгалын хямралд өртөөд зогсохгүй урт хугацааны колоничлолын үр дагавар зэрэг аливаа хямралыг эрчимжүүлдэг улс төр, нийгэм, эдийн засгийн суурь хүчин зүйлсийн нөлөөлөлд өртдөг. Уур амьсгалын өөрчлөлт нь колоничлолын үр дагаврыг хадгалаад зогссонгүй. Энэ нь колоничлогч байсан гүрнүүдийн үлдээсэн суурьшмал нийгэмд тулгуурласан колоничлолын шинэ хэлбэр юм. Уур амьсгал судалдаг эрдэмтэд Жэймс Хансен, Макико Сато нар 1751-2014 онд АНУ, Их Британи, Герман улсуудын нэг хүнд оногдох хүлэмжийн хийн (ХХ) ялгаруулалт дэлхийн дунджаас дор хаяж 6 дахин их байсныг хэлж байжээ. Тухайн үед Орос, Канад, Австрали зэрэг орон дэлхийн дунджаас 4-5 дахин их хүлэмжийн хий ялгаруулж байжээ. Уур амьсгалын өөрчлөлтөд хариуцлага хүлээлгэх нь дэлхий дахины баян чинээлэг орнуудтай тулна гэсэн үг. 1990-2015 онд дэлхийн хүн амын хамгийн баян 10% нь (630 сая хүн) нийт нүүрстөрөгчийн ялгаруулалтын талаас илүү хувийг ялгаруулж

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИВУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТҮЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ ХУРААНГУЙ

Эмнести Интернэшнл

байсан бол хамгийн ядуу хүн амын 50% нь (3.1 тэрбум орчим хүн) хуримтлагдсан утаа угаарын дөнгөж 7%-ийг ялгаруулж байсныг Оксфам тооцоолж гаргажээ. Дэлхийн хүн амын хамгийн чинээлэг 1% нь дэлхийн хамгийн ядуу хүн амын тэн хагасыг нийлүүлснээс хоёр дахин их нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂) ялгаруулж байв.

УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ХҮНИЙ ЭРХ ЧУХАЛ

Улс, орнууд олон улсын хүний эрхийн эрх зүйгээр уур амьсгалын хямралтай холбоотой асуудлыг шийдвэрлэх хуулийн болоод уг хуулиа хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хүний эрхэд учирч болохуйц хохирол, түүний дотор урьдчилан тооцоолж болох урт хугацааны хохиролд дорвитой арга хэмжээ аваагүй тохиолдолд энэ нь улс орнууд хүний эрхийн эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ зөрчиж байна гэсэн үг.

Олон улсын хүний эрхийн эрх зүй нь өргөн хүрээний хуулийн хариуцлага хүлээлгэдэг бөгөөд үүнийг ашиглан бид уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үр дүнтэй бодлого, арга хэмжээ явуулахыг шаардаж болно. Мөн хүний эрхийн эрх зүй нь улс орнуудыг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь тал бүрээр дэмждэг. Үүний адил хүний эрхийн зарчим, хэм хэмжээ нь уур амьсгалын хямралтай холбоотой асуудлаар бизнес, аж ахуйн үйл ажиллагааны үүрэг, хариуцлагын гол удирдамж болдог. Тиймээс хүний эрх нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн хүний эрхэд учирсан хохиролд улс орнууд болон корпорациудад хариуцлага хүлээлгэх ач холбогдолтой.

Уур амьсгалын аюултай байдлыг хүний эрхийн хямрал гэж үзэх нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, яаралтай хариу арга хэмжээ авхуулах аян, үйл ажиллагаа хийх иргэдийг идэвхжүүлэх хүрээг нь тэлэхэд чухал юм. Зөвхөн байгаль орчныг хамгаална гэхээс илүүтэй уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар дотооддоо хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэх эсвэл үүнийг нийгэм анхаарч байгааг харуулсан хүний эрхэд суурилсан олон нийтийг хамарсан аян өрнүүлэх, нөлөөллийн ажил хийх нь шийдвэр гаргагчдад уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хүний эрхэд нийцсэн шийдвэр гаргахад түлхэц өгөх юм.

НҮБ-ын хэд хэдэн төрөлжсөн байгууллага, мэргэжилтэн, иргэний нийгмийн байгууллага болон уугуул иргэд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга хэмжээг бэхжүүлэхэд хүний эрх чухал ач холбогдолтой гэж үзжээ.

Цаг уурыг зохицуулах арга хэмжээ, бодлогууд нь олон нийтийн оролцоо, уугуул иргэдийн чөлөөтэй, урьдчилан мэдэгдэж, мэдээллээр хангасны үндсэн дээр зөвшөөрөл авах эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид, тэгш байх мөн хөдөлмөрлөх эрхийг хүндэтгэх зэрэг хүний эрхийн зарчмуудад нийцсэн байх нь улс орнуудын нэгдэн орсон хүний эрхийн гэрээ, конвенциудад суурилсан хууль ёсны үүрэг хариуцлага юм. Энэ нь нүүрстөрөгчгүй эдийн засагт шилжих, мөн хамгийн орхигдсон бүлэг болох ядуусын эрхэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр дэлхийн дулаарлыг 1.5°C хэмд хязгаарлах эсвэл түүнээс доогуур хэмжээнд барих нөхцөлөөр хангахад үр дүнтэй арга юм. Хүний эрхийн зарчим, хэм хэмжээг бататгаж, хүний эрхийн тогтолцоо, арга хэрэгсэл, тактикуудыг хүний эрхийг сахиулахад ашиглах нь хүн ард, байгаль орчинд бодит, эерэг өөрчлөлт авчрах уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг илүү санаачилгатай үйл ажиллагаа явуулахад чухал хувь нэмэр болох юм.

Уур амьсгалын хямралд хамгийн их өртдөг эмэгтэйчүүд, уугуул иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шилжин суурьшигчид болон дүрвэгчид зэрэг нийгмийн бүлгүүдийг зөвхөн хохирогчоор харах бус тэднийг хүн бүр олон улс, үндэстэн болон орон нутгийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох үйл ажиллагаанд өөрчлөлт хийх гол төлөөлөгч, удирдагчид хэмээн хүлээн зөвшөөрөх нь зүйтэй.

Энэхүү товхимолд Эмнести Интернэшнлийн олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд хийсэн дүн шинжилгээ, хохирол, нөлөөллийг бууруулах, дасан зохицох зэрэг уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гол асуудлууд хүний эрхтэй хэрхэн холбогддог тухай тусгасан юм. Уур амьсгалын хямралыг зохицуулахад хүний эрхийн үүднээс хяналт тавихын ач холбогдол нь уур амьсгалын өөрчлөлт хэрхэн хүний эрхэд нөлөөлж, ялгаварлан гадуурхалт болон тэгш бус байдлыг нэмэгдүүлж байдгийг тайлбарласан. Энэ товхимолд улс орнууд, корпорациудын хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагыг аль болох тодорхой дурдахыг зорилго.

Энэ товхимол дахь Эмнести Интернэшнлийн байр суурь нь олон улсын болон бүсийн хүний эрхийн гэрээний байгууллагууд, шүүхийн шийдвэр зэрэг хүний эрхийн эрх зүйд үндэслэсэн болно. Эмнести Интернэшнлийн энэхүү байр суурийг НҮБ болон бүсийн төрөлжсөн байгууллагууд, бие даасан хүний эрхийн шинжээчид, ТББ-ууд, тинк танкууд болон шинжлэх ухааны академиудын өнгөрсөн арван жилийн ажил, уур амьсгалын өөрчлөлтийн төлөөх шударга ёсны тэмцлийн тэргүүн эгнээнд байдаг жирийн иргэдийн бүлэг, нийгмийн хөдөлгөөнүүд ажлууддаа тусгасаар ирсэн болно.

ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ ҮҮСГЭЖ БҮЙ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ЗОГСООХ ДОРВИТОЙ АЛХАМ ХИЙСЭНГҮЙ

Уур амьсгалын өөрчлөлтийг зогсооход улс орнууд хамтарч ажиллахаар санал нэгдэж 2015 оны Парисын хэлэлцээрийг баталсан ч өнгөрсөн хугацаанд хийсэн оролдлогууд нь хүн төрөлхтөн болон экосистемд сүйрлийн үр дагавартай нөлөөллөөс зайлсхийхэд шаардлагатай арга хэмжээнээс доогуур байсаар байна. Улс орнууд хамтран хүлэмжийн хийг бууруулснаар дэлхийн температурын дундаж өсөлтийг 1.5°C хэмээс ихэсгэхгүй байх боломжтой байсан талаар 2018 онд Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын мэргэжилтний зөвлөл баталж байсан. 2030 он гэхэд хүлэмжийн хийг дэлхийн хэмжээнд 2010 оны төвшнөөс 45%-иар бууруулж, 2050 он гэхэд цэвэр тэг үзүүлэлтэд хүргэх шаардлагатай байна. Гэвч хүлэмжийн хийн ялгаруулалт 2010-2019 оны хооронд нэмэгдсээр байсан. КОВИД-19 цар тахлын эсрэг хариу үйлдэл үзүүлэн олон улс тусгаарлалтын арга хэмжээ авснаар хүлэмжийн хийн ялгаруулалт 2020 онд түр зуур буурсан ч уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хэмжээний хангалттай байсангүй.

Олон засгийн газар, тэр дундаа уур амьсгалын хямралын түүхэн хариуцлагыг хүлээх томоохон орнууд болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэхэд эрдэмтэн, судлаачдын тодорхойлсон, урьд нь хийж байгаагүй, дорвитой арга хэмжээ авахад улс төрийн шийдэмгий байдал дутмаг байна. 2015 онд батлагдсан Засгийн газруудын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөөний эхний үе шатаар явахад 2100 он гэхэд хамгийн багадаа дэлхийн дулаарлыг 3°C хэм хүргэхээр байгаа юм. 2030 он хүртэл нүүрстөрөгчийг саармагжуулах хэд хэдэн шинэ зорилт зарлагдсан ч, ихэнх улсад ялангуяа Их-20-ийн гишүүн, чинээлэг орнууд уур амьсгалын өөрчлөлтийн хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийхэд сайнаар нөлөөлөх, хүний эрхэд нийцсэн уур амьсгалын төлөвлөгөөг өнөөг хүртэл баталж чадахгүй байна.

Дэлхийн дулаарлын таамагласан төвшнөөс үүсэх үр дагавар хүмүүсийг эрхээ эдлэх боломжгүй болгож байгаа билээ. Одооноос зөрүүг арилгаж эхлэх нь хүний эрхийн үүднээс гол анхаарлаа хандуулах бидний өнөөдрийн асуудал юм. Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах талаар зохистой арга хэмжээ авахгүй байх, мөн хүний эрхийн зөрчил үүсгэдэг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүссэн хохирлоос эрх нь зөрчигдсөн хүмүүст шүүхээр хамгаалуулах боломж үл олгох нь хүний эрхийн зөрчил юм. Уур амьсгалын өөрчлөлтийн зайлшгүй үр нөлөөнд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, мөн шалтгаан, хор хөнөөлийнх нь талаарх мэдлэгийг хүмүүст олгох нь чухал. Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хүсэл эрмэлзэл хангалтгүй байгаагаас үүдсэн

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТҮЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ ХУРААНГУЙ

Эмнести Интернэшнл

хүний эрхийн зөрчил нь бусад зөрчлөөс ялгаагүй ч хамрах хүрээ нь илүү өргөн, олон сая хүний ирээдүйг гэлтгүй өнөө үед цаг бусын үхэл, өлсгөлөн, өвчин болон нүүлгэн шилжүүлэлтэд өртүүлж, хүний эрхийн зөрчлийн зогсошгүй тойрог бий болгож байна. Аль хэдийн тогтсон шударга бус байдалд дарлагдсан хүмүүсийг одоогийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхал руу нэмж түлхэж байна. Уур амьсгалын хямралыг бүрэн шийдвэрлэхгүй байгаа нь ялгаварлан гадуурхлын хэлбэр мөн.



Франц дахь Эмнести Интернэйшнлийн дэмжигчид дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг жагсаалд оролцож буй нь. 2019 он, Парис. Зургийг © Бенжамин Жиретт / Ханс Лукас

ЧИНЭЭЛЭГ УЛС ОРНУУД ДОТООДДОО БОЛОН ГАДААДАД Ч ХУРДАЙ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЁСТОЙ

Уур амьсгалын өөрчлөлт хилээр хязгаарлагдахгүй бөгөөд бүх улс орныг хүлэмжийн хийн ялгаруулалтаа бууруулах, аль болох хурдан нүүрстөрөгчийн ялгаруулалтыг тэг төвшинд хүргэх, өөрсдийн чадах хэмжээгээр уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход нь хүмүүст туслахыг шаарддаг. Гэхдээ энэ нь улс орнууд уур амьсгалын хямралд ижил, тэгш хариуцлагатай байх эсвэл уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад тэнцүү үүрэг хүлээнэ гэсэн үг биш юм. Дэлхийд нэг жилд ялгарч буй нүүрстөрөгчийн нийт хийн 78%-ийг “Их 20”-ийн улсууд үйлдвэрлэж байгаа бөгөөд аж үйлдвэржилтийн хувьсгалын үеэс хойших хугацаанд ялгаруулсан нүүрстөрөгчийн үзүүлэлтээрээ зарим нь илүү өндөр хариуцлага хүлээхээр байгаа юм. Тодруулбал, түүхэн дэх хамгийн их хий ялгаруулагчид нь өөрсдөө үүний эсрэг хүчтэй хариу арга хэмжээ авах чадвартай чинээлэг улс орнууд байдаг.

Олон улсын хүний эрхийн эрх зүйд шууд бусаар тусгагдсан нийтлэг боловч ялгаатай үүрэг хариуцлага, тус тусын боломж боллоцоонд суурилах зэрэг зарчмын хүрээнд чинээлэг улс орнууд хөгжиж буй улс орнуудаас малтмал түлшний үйлдвэрлэлийг илүү

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!
ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХНИЙГ ХАМГААЛАХЫН ТҮЛД ЮУ ХИЙХ ШААРЛАГАТАЙ ТУХАЙ
ХУРААНГУЙ

хурдан зогсоохын тулд эдийн засгаа нүүрснээс хараат бус болгож, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах үйлсэд тэргүүлэн оролцох нь зохистой. Хэдий тийм боловч өнөөг хүртэл чинээлэг орнуудын дийлэнх нь хурдтай хариу арга хэмжээ авахад бэлэн биш байна. Чинээлэг улс орнуудын хувьд 2050 он гэхэд хүлэмжийн хий ялгаруулахыг тэглэх зорилт тавьж, төлөвлөгөө гаргасан нь хэт удаан, үнэндээ хожимдсон байна.

Олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргээрээ чинээлэг орнууд хөгжиж буй орнуудад уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах зорилтууддаа хүрэх, дасан зохицох үр дүнтэй аргуудыг хэрэгжүүлэхэд туслах, хангалттай санхүүгийн дэмжлэг үзүүлэх, мөн уур амьсгалын хямралаас үүдэн аль хэдийн алдагдал, хохирол амсаад буй хүмүүст зориулсан бусад төрлийн арга хэрэгсэл, нөхөн төлбөрийг олгох ёстой.

Гэсэн ч чинээлэг орнууд энэ үүргээ биелүүлэхгүй байна. Хөгжиж буй орнууд дахь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицоход дэмжлэг үзүүлэх олон улсын санхүүжилт нэмэгдэж байгаа ч энэ нь дэлхийн температурын дундаж өсөлтийг аж үйлдвэржилтээс өмнөх үеийн төвшнөөс дээгүүр, 1.5°C-аас доогуур хэмд барих, хөгжиж буй орны уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, түүнд дасан зохицох оролдлогыг төлөвшүүлэх шаардлагатай арга хэрэгслээс хол байна. Тодруулбал, хөгжингүй орнуудаас 2020 он гэхэд жил бүр 100 тэрбум ам.долларыг уур амьсгалын өөрчлөлтийг



Нигери улсын Нигери Делтад байрлах түүхий нефть олборлолтын газар дахь хийн шаталт. 2010 оны 4-р сар. Зургийг: © ЭсЮу-Анна Трессе

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ ХУРААНГУЙ

Эмнести Интернэшнл

бууруулах, дасан зохицох ажиллагаанд нь зориулж хөгжиж буй орнуудыг дэмжих зорилт биелээгүй. Санхүүжилтийн ихэнх нь мөнгөн тусламж бус зээл хэлбэрээр өгсөн бөгөөд үүний тал хувь нь хөнгөлөлтгүй зээл байсан нь зээлийг өгөөмөр бус, зохисгүй нөхцөлөөр санал болгожээ.

Түүгээр ч зогсохгүй улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавраас үүдсэн алдагдал, хохиролд зориулсан нэмэлт, шинэ санхүүжилтийг эргэлтэд оруулах тохирсон санхүүгийн тогтолцоогүй байна. Шударгаар хуваалцах, хувиа төлөхөөс татгалздаг чинээлэг орнууд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл явдлын улмаас жил бүр дүрвэсэн сая сая хүн эсвэл оршин тогтнолд нь аюул нүүрлэсэн Номхон далайн нам дор арлын оршин суугчдаас нүүр бууруулж байна.

Шударга хувиа төлөхөөс татгалздаг чинээлэг улс орнууд цаг уурын өөрчлөлттэй холбоотой үйл явдлын улмаас жил бүр дүрвэсэн олон сая хүн эсвэл оршин тогтнох аюулд нүүрлэсэн Номхон далайн нам дор орших арлуудын оршин суугчдаас нүүр бууруулж байна.

МАЛТМАЛ ТҮЛШ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХАД СӨРӨГ НӨЛӨӨТЭЙ

Нүүрс, хий зэрэг малтмал түлш шатаах нь хүлэмжийн хий ялгаруулалтын гол эх үүсвэр болдог бөгөөд энэ нь дэлхийн хүлэмжийн хий ялгаруулалтын 70%-иас илүүг бүрдүүлдэг. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Парисын Хэлэлцээрийн дагуу улс орнуудын хүлээсэн үүрэг хариуцлага байгаа ч малтмал түлшний хэрэглээнээс үүссэн нүүрс хүчлийн ялгаруулалт 2010-2018 онд жил бүр ойролцоогоор 1%-иар өссөн байна. Нүүрс хүчлийн хий 2019 онд 2018 онтой харьцуулахад бага зэрэг өндөр байсан бол 2020 онд КОВИД -19 цар тахлын улмаас 5.8%-иар буурсан байна. Олон улсын эрчим хүчний агентлаг нүүрстөрөгчийн ялгаруулалтыг 2021 онд 4.8 хувиар өснө гэж тооцоолсон нь түүхэн дэх хоёр дахь том жилийн өсөлт байж магадгүй юм. Одоогийн байдлаар жилийн нийт нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂) нь уур амьсгалын асуудлаарх олон улсын хэлэлцээр эхэлсэн 1990 оны үеийн ялгаруулалтаас 62%-иар илүү байна.

Дэлхийн дундаж температурын өсөлтийг 1.5°C хэмд барихын тулд нийт малтмал түлш үйлдвэрлэлийг 2030 он хүртэл жил бүр 6%-иар бууруулах шаардлагатай. Тийм хэдий ч улс орнуудад жил бүр 2%-иар өсөх төлөв ажиглагдаж байна хэмээн 2020 онд НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр (НҮББОХ/ЮНЕП) тооцоолсон. Ковид-19 цар тахал, түүний эдийн засгийн үр дагаврын хариу арга хэмжээ болгож аж үйлдвэржсэн орнуудын нилээдгүй хэсэг нь малтмал түлшний компаниуд, агаарын тээврийн салбар болон нүүрстөрөгчөөр агаар бохирдуулдаг бусад компаниудыг ямар ч болзолгүйгээр батлан даах, дэмжих зорилгоор татвар төлөгчдийн мөнгийг тараасан.

Малтмал түлшний үйлдвэрлэлийг богино хугацаанд бууруулах нь дэлхийн дундаж температурын өсөлтийг 1.5°C хэмд барих цорын ганц арга гэдгийг Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын мэргэжилтний зөвлөл (IPCC)-өөс батлаад байна. Тиймээс эрэлт, нийлүүлэлтийн аль алинд нь чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай байна. Нийлүүлэгчийн зүгээс хайгуул, олборлолт, үйлдвэрлэл, гадаад нийлүүлэлт болон холбогдох хөрөнгө оруулалтуудыг хязгаарлах замаар малтмал түлшний үйлдвэрлэлийг бууруулахыг оролдох хэрэгтэй. Ингэхдээ малтмал түлшний хэрэглээ болон эрэлтийг бууруулах байдлаар оролцох хэрэгтэй. Тухайлбал, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, хүний эрхийг зөрчихгүйгээр үйлдвэрлэсэн нийгмийн хариуцлагатай сэргээгдэх эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглээг багасгах зан үйлийн өөрчлөлтийг дэмжих мөн малтмал түлшнээс сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ, үйлдвэрлэлд шилжихэд тухайн бүс нутагт санхүүгийн болон бусад урамшуулал, хөшүүргийг бий болгох байдлаар оролцоно.

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!
ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХНИЙГ ХАМГААЛАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ
ХУРААНГУЙ

Эрхээ эдлэхэд нөлөөлж буй уур амьсгалын хямралын сөрөг нөлөөллийг байж болох хамгийн доод төвшин хүртэл нүүрс хүчлийн ялгарлыг бууруулах, малтмал түлшний хэрэглээ, үйлдвэрлэлийг зайлшгүй хурдтай багасгах ёстой. Үүний зэрэгцээ сэргээгдэх эрчим хүчний болон нүүрстөрөгчийн ялгаруулалгүй эдийн засагт шилжих шилжилт нь тогтвортой бөгөөд хүн бүрт хүртээмжтэй эрчим хүчийг бий болгож, давуу эрхгүй эсвэл орхигдсон нийгмийн бүлгүүд, хувь хүмүүст хохиролгүй байхын тулд шударга, тогтвортой, хүний эрхэд нийцсэн байх ёстой. Тухайлбал, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах ажил, ой хамгаалах төслүүд нь уугуул иргэдийн өвөг дээдсийнхээ газар нутгийг эзэмших эрхийн баталгааг хангаж, тэдний эрхийг баталгаажуулах ёстой бөгөөд ингэснээр тэд албадан нүүлгэлтийн эсрэг эрх зүйн хамгаалалттай болох юм. Нүүрстөрөгчид тавих татвар нь шударга бус байдлыг нэмэх бус багасгах ёстой бөгөөд ийм байдлаар мөнгөн тэтгэмж, буцалтгүй тусламж болон татварын шинэчлэлээр бага орлоготой бүлгүүдийг аливаа сөрөг нөлөөллөөс хамгаалах, мөн тэднийг эрчим хүчээр хангадаг малтмал түлшний компаниуд, чинээлэг хэрэглэгчдэд үүрэг, хариуцлага оногдуулах ёстой.

Нүүрстөрөгчийн хэмжээг 1.5°C хэмд барих мөн өөрсдийн боломжид тааруулан тухай бүрт нь малтмал түлшний хэрэглээг бууруулж чадахгүй байгаа улс орнууд хүний эрхийг зөрчсөөр байна. Үүний нэгэн адил дундаж төвшнийг 1.5°C -т барих шаардлагатай энэхүү цаг үед нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах хангалттай арга хэмжээ авахгүйгээр малтмал түлшний хэрэглээ, үйлдвэрлэлийг эрчимжүүлдэг компани, санхүүгийн байгууллагууд хүний эрхийг зөрчдөг үйл ажиллагаандаа хариуцлага хүлээх хэрэгтэй.

ЗӨВХӨН ХҮЛЭМЖИЙН ХИЙГ ТЭГЛЭХ БУС, ИНГЭХ ЯВЦДАА Ч ХҮНИЙ ЭРХИЙГ ЗӨРЧЛИЙГ ТЭГЛЭХ НЬ ЧУХАЛ

Зарим уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах төсөл хөтөлбөрүүд нь ялгаварлан гадуурхалд ихэвчлэн өртдөг, орхигдсон бүлгүүдэд эрхээ эдлэхэд нь харьцангуйгаар шууд сөргөөр нөлөөлж байгааг олж тогтоосон байна. Тухайлбал, тухайн газар нутагт аж төрдөг уугуул иргэд, орон нутгийн оршин суугчдын эрхийг зөрчин сэргээгдэх эрчим хүчний төсөл, био түлш, тариалан, тусгай хамгаалалтын газрын төслүүдийг хэрэгжүүлэхээр санаачилсан байдаг. Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга хэмжээ болгож ургамлын гаралтай био түлш эсвэл нүүрстөрөгчийг шингээх, хадгалах биоэнерги (BECCS) зэрэг нүүрстөрөгчийг зайлуулах механизмд хэт найдах нь хоол хүнсээр хангагдах хүний эрхэд ноцтойгоор нөлөөлж болзошгүй.

Цахилгаан тээврийн хэрэгсэл, сэргээгдэх эрчим хүч хуримтлуулагч, дахин цэнэглэгддэг зайны их хэмжээний үйлдвэрлэл нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулан сэргээгдэх эрчим хүчинд шилжихэд ач холбогдолтой нь гарцаагүй. Гэвч энэ нь газрын ховор элементийг их хэмжээгээр олборлох шаардлагатай болдог тул аюултай хог хаягдал, усны хэт их хэрэглээ гэх мэтээр байгаль орчинд хохирол ихтэй, орон нутгийн иргэдийн эрхийг өргөн хүрээнд зөрчих асуудалд хүргэдэг. Эмнести Интернэшнлийн судалгаагаар уур амьсгалын өөрчлөлт нь хэт хуурай экосистемд илүү ноцтой нөлөөлж байгааг харуулсан.

Эдийн засгаас нүүрсний хэрэглээг халах, нийтээрээ уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нөхцөлийг бүрдүүлэх нь уур амьсгалын хямралыг зохицуулах чухал зорилтууд юм. Ингэхдээ эдгээр зорилтыг жигд, тэгш хангах нь асуудал болсоор байна. Тиймээс тус шилжилтийг хийхдээ ядуу, буурайдаа дарамт, нэрмээс болохгүйгээр хийх ёстой.

Энэхүү шилжилтийн суурь бодлогыг тодорхойлохдоо тэгш эрх, оролцоо зэрэг хүний эрхийн зарчимд нийцүүлэх ёстой.

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИВУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ ХУРААНГУЙ

Эмнести Интернэшнл

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс иргэдээ хамгаалах улс орнуудын хариу арга хэмжээ нь хүний эрхийн зөрчил үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, ийм зөрчил үүсгэдэг хариу арга хэмжээ авахаас зайлсхийх ёстой.

Мөн тэд нүүрстөрөгчөөс ангижрах, хүний ихэнх эрхээ эдлэхэд саад болдог тэгш бус байдлыг арилгах, ядуурлыг бууруулах боломжийг ашиглан уур амьсгалын өөрчлөлтөд өртсөн бүх ажилтан, болон нийгмийн бүлгүүдэд зориулан шударга шилжилт хийх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй.



Сэнгер Уугуул иргэд – Кенийн эрх баригчид ойн төсөлд зориулан зам гаргахаар Кенийн баруун өндөрлөг дэх Эмбобутын ойгоос Сэнгер уугуул иргэдийг албадан нүүлгэж байгаа нь. Сэнгерүүд Эмбобутын ойд хэдэн зуун жил амьдарч байна гэдэг. Тэд эрхээ хамгаалж байгаа бөгөөд шаардлага нь маш тодорхой. Засгийн газраас газрынхаа эрхийг хүлээн зөвшөөрөх мөн ой модыг хамгаалахад хамтран ажиллах ёстой хэмээн тэд үзэж байгаа юм.

Зургийг: © Эмнести Интернэшнл

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!
ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТҮЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ
ХУРААНГУЙ

УЛС ОРНУУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Эмнести Интернэшнлээс улс орнуудад хандан уур амьсгалын хямралын үед хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх талаар олон улсын эрх зүйн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд зайлшгүй хийх алхмуудын талаар дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ ДАРУЙ ЗОГСООЖ ХҮМҮҮСИЙГ ХАМГААЛАХ

Хүний эрхийн хуулиар төр нь өөрийн нутаг дэвсгэр дээр гарсан төрийн болон төрийн бус оролцогчдын хууль бус үйлдлээс үүдэлтэй байгаль орчны хор хөнөөлөөс иргэдийг хамгаалах, эрхийг нь эдлүүлэх үүрэгтэй. Энэ нь улс орнуудыг хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах талаар шаардлагатай арга хэмжээ авч, уур амьсгалын өөрчлөлтийн хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхийг үүрэг болгодог. Ялангуяа, улс орнууд дэлхийн хэмжээнд хүлэмжийн хийн ялгарлыг аль болох богино хугацаанд бууруулахын тулд үндэсний болон олон улсын хамтын ажиллагааны хүрээнд боломжит бүх арга хэмжээг авах ёстой бөгөөд дэлхийн дундаж температурын хэмжээг аль болох бага бөгөөд 1.5°C-ээс хэтрүүлэхгүй байх ёстой.

Тодруулбал, улс орнууд дараах зүйлсийг хийх ёстой:

- Үндэсний хэмжээнд нүүрстөрөгчийн хийг бууруулах, нүүрстөрөгчөөс ангижрах урт хугацааны зорилт, стратеги бүхий уур амьсгалын асуудлаар Үндэсний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх. Энэ нь хүний эрхийг хангахад нийцтэй байж улс орнуудын үүрэг хариуцлага, чадавхийг тусган, нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах зорилт, холбогдох хэрэгжилтийн төлөвлөгөө, уур амьсгал, эрчим хүчний бодлого, дэлхийн дундаж температурын өсөлтийг аж үйлдвэржилтээс өмнөх үеийн төвшнөөс дээш 1.5°C хэмээс хэтрүүлэхгүй аль болох бага төвшинд барих үүрэг, амлалттай нь тохирох;
- Нүүрстөрөгчийн ялгарлыг бодитоор бууруулдаггүй, хүний эрхийн аюулгүй байдлыг анхаардаггүй худалдаанд зориулсан олон талт механизмаас татгалзах;
- Хамгийн их бохирдол үүсгэдэг малтмал түлшнүүд, нүүрс, хүлэр, хий, газрын тос өрөмдлөг, битум хар тос зэргийн үйлдвэрлэлийн хэлбэрийг болон малтмал түлшний тэлэлтийг (боломжит эрчим хүчээр хангагдаагүй хүмүүст зориулсан түр арга болох сайжруулсан зуухны хөтөлбөрүүдээс бусад тохиолдолд) нэн даруй зогсоох зэргээр хамгийн их бохирдол үүсгэж буй малтмал түлшний татаасыг арилгахаас эхлэн ялгаруулалтад хүлээх хариуцлага болон өөрсдийн чадавхид тулгуурлан аль болох хурдтайгаар малтмал түлшний үйлдвэрлэл, зарцуулалтаас сэргээгдэх эрчим хүч рүү шилжих шилжилтийг хэрэгжүүлж тэдгээрийг хэрэглээнээс хурдан гаргах;
- Тогтвортой хөгжлийн зорилго, хийн ялгарлыг бууруулах зорилгоор өөрийн чадавх, хариуцлагад үндэслэн хүний эрхэд нийцсэн үйлдвэрлэл бүхий сэргээгдэх эрчим хүчинд 2050 он гэхэд бүрэн шилжих;
- Тогтворгүй, мөлжлөгийн шинжтэй хөдөө аж ахуй, хүнсний тогтолцооноос хүний эрхэд нийцсэн, тогтвортой хөдөө аж ахуй, газрын менежментийг дадал болгох, дэмжих тогтвортой, хүний эрхэд нийцсэн бодлогыг хүнсний тогтолцоонд нэвтрүүлэх; Ахуй амьдрал, ундны ус, хоол хүнс, орон байраар хангагдах боломжийн хувьд газраасаа хамаарал бүхий бүх нийгмийн бүлгийн газрын болон эд хөрөнгө эзэмшлийн эрх зүйн аюулгүй байдлыг хангах;

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИВД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ ХҮРААНГУЙ

Эмнести Интернэшнл

- 2030 он гэхэд ой мод устгахыг зогсоох, байгалийн ойг нөхөн сэргээх үр дүнтэй бодлого баталж, хэрэгжүүлэх; Хүний эрх, байгаль орчинд үзүүлэх эрсдэлийг бүрэн тооцоолсны үндсэн дээр уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад нөлөөлөх био эрчим хүчийг ашиглах асуудлыг эргэж харах; Ялангуяа ойн биомасс болон ургамлын гаралтай био түлшид суурилсан био эрчим хүчний хэрэглээ, үйлдвэрлэлд оногдуулсан татвараас чөлөөлөх болон татаас өгөхийг үе шаттайгаар болих, зогсоох. Био эрчим хүчний төслийг батлагдахаас өмнө уугуул иргэд, орон нутгийн бүлгүүдийн утга учиртай оролцоог хангах, тэдэнтэй зөвлөлдөж, чөлөөтэй, урьдчилан мэдэгдэж, мэдээллээр хангасны үндсэн дээр зөвшөөрөл авах, уугуул иргэдийн эрхийг хүндэтгэхийн зэрэгцээ хүний эрхэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг заавал хийхийг төр баталгаажуулах;
- Нүүрстөрөгчийн давхар исэл /CO₂/-ийг арилгах, бусад дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ зэрэг хүний эрхийг зөрчиж буй үйл ажиллагаанаас зайлсхийхийн тулд дулаан ялгаруулалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах үйл ажиллагааг нэн тэргүүнд тавих; Нүүрстөрөгчийн давхар исэл /CO₂/-ийг арилгах арга хэмжээнүүдээс байгальд тулгуурласан ялангуяа, экосистем, хүний эрхэд хамгийн үр дүнтэй, шийдлүүдийг нэн тэргүүнд тавих;
- Хувийн авто машин, агаарын тээврийн эрэлт хэрэгцээг бууруулах өргөн хүрээний, олон талт, хүний эрхэд нийцсэн тууштай бодлого, арга хэмжээг батлах, лити-ион батарейн нийлүүлэлт, хэрэглээнээс учирч болох хүний эрхийн эрсдэл, хүрээлэн буй орчны хохирлыг анхаарч тооцон бензин, дизел, газ зэрэг түлшээр ажилладаг автомашиныг цахилгаан тээврийн хэрэгслээр солих; нөхөн төлбөрт найдалгүйгээр нислэгийн компаниудад нүүрстөрөгчийн ялгарлыг сайтар бууруулах талаар тодорхой хугацаат үүрэг хүлээлгэх; дэлхийн дулаарлыг 1.5 °C хэмийн зорилтот түвшинд барихаар далайн усан онгоцны утаа, угаарыг бууруулах дүрэм, журам гаргах зэргээр тээврийн салбарын хийн ялгарлыг бууруулах хүний эрхэд нийцсэн тууштай арга хэмжээ авах;
- КОВИД-19 цар тахлын үед хүний эрх болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааг анхаарч байгаль орчинд хурдтай бөгөөд тогтвортой нөхөн сэргээлт хийх. Ялангуяа, цар тахал болон уур амьсгалын хямралаас үүдэн улам даамжирсан тэгш бус байдлыг арилгахад хувь нэмэр болох нүүрстөрөгчийн хийгүй эдийн засаг, уян хатан нийгмийг бий болгох урамшуулалт багц, нөхөн сэргээх арга хэмжээ авах.

Түүнчлэн чинээлэг, аж үйлдвэржсэн улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах хүчин чармайлтаа нэн эрчимжүүлж, хөгжиж буй орнуудад үндэслэлгүй хүлээлт үүсгэхээс зайлсхийх ёстой. 2030 он гэхэд дэлхийн хүлэмжийн хийн ялгарлыг 2010 оныхоос 45%-иар бууруулах зорилтын хүрээнд дараах зүйлсийг хийх хэрэгтэй:

- 2030 оноос өмнө ялгарлыг хоёр дахин бууруулж, 2030 он гэхэд нүүрстөрөгчийн хэмжээг тэг болгох буюу аль болох богино хугацаанд хүний эрхийн нөхцөлийг сайжруулах хийн ялгарлыг бууруулах хамгийн эрчимтэй зорилтууд баталж хэрэгжүүлэх;
- 2030 оноос хэтрэхгүйгээр хүний эрхэд нийцсэн үйлдвэрлэл бүхий сэргээгдэх эрчим хүчинд шилжих, малтмал түлшийг хэрэглээнээс халах;
- Нүүрс, хүлэр, өрөмдлөг, битум хар тосны үйлдвэрлэл болон хамгийн их бохирдол үүсгэдэг малтмал түлшний хэрэглээ болон үйлдвэрлэлийг аль болох 2030 оноос хэтрүүлэхгүйгээр зогсоох;
- Малтмал түлшний татаасыг нэн даруй зогсоох;
- Өөрсдийн газар нутаг дахь малтмал түлшний үйлдвэрийг зогсоож, шинэ

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!
 ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТҮЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ
ХУРААНГУЙ

дэд бүтэц байгуулах олборлолт, үйлдвэрлэл болон хайгуулыг тэлэх хөрөнгө оруулалтыг хуулиар хориглох;

- Чинээлэг орнуудын хэрэглээнээс гарсан малтмал түлшийг хөгжиж буй орнуудын үйлдвэрлэлийн эх үүсвэр болгон солихгүйгээр бусад улс дахь малтмал түлшний төслүүдийг санхүүжүүлэхээ зогсоох.

УУР АМЬСГАЛЫН НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН ХҮМҮҮСТ ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХОД НЬ ТУСЛАХ

Улс, орнууд нь өөрсдийн шүүх эрх мэдлийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн урьдчилан харж, зайлшгүй болох нөлөөлөлд дасан зохицоход нь туслах бүх хэрэгцээтэй арга хэмжээг батлах зэргээр хүний эрхийн үүднээс уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах хуулиар хүлээсэн үүрэгтэй.

Ялангуяа, улс орнууд нь дараах зүйлсийг хийх хэрэгтэй:

- Урьдчилан тооцоолох боломжтой, гарцаагүй болох уур амьсгалын хямралаас хамгаалах хүний эрхэд нийцсэн дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх, батлах;
- Өөр өөр бүлгийн хэрэгцээ, шаардлагыг анхаарч уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах стратеги боловсруулах, хэрэгжүүлэх. Энэ нь нэн тэргүүнд ихээхэн эрсдэлд өртөх хүмүүсийг анхаарч, тэдэнд шаардлагатай нөөцийг хуваарилж бүх хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх, мөн нийгмээс орхигдох, гадуурхагдах, ялгаварлагдах зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөө, хохирлын эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлсийг тодорхойлох, анхаарахыг шаарддаг;
- Хамгийн их орхигдсон бүлэг, орон нутгийн иргэд, хувь хүмүүст дасан зохицох арга хэмжээг нэн тэргүүнд авч, жендэрийн тэнцвэргүй байдлыг арилгах, уугуул иргэд болон бусад орон нутгийн бүлгүүдийн уламжлалт мэдлэгээс мэдээлэл авахыг эрмэлзэх.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ ИРГЭДИЙН ЭРХЭД НИЙЦСЭН БАЙДЛЫГ ХАНГАХ

Улс орнууд уур амьсгалын бодлого, санаачилгуудыг хэрэгжүүлэхдээ хүний эрхийг хүндлэх, хангах, хамгаалах ёстой.

Ялангуяа, эдийн засгийг нүүрснээс ангижруулах, дасан зохицох чадвартай нийгэм рүү шилжих үйл явц нь улс орнуудын хүний эрхийн үүргийн дагуу хүн бүрт шударга, ялгаварлалгүй байхыг баталгаажуулж, хүйс, арьс өнгө, хөгжлийн бэрхшээл, үе хоорондын тэгш байдлыг дэмжин улс орнууд дотооддоо болон улс хоорондын тэгш бус байдалтай тэмцэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

Ялангуяа, улс орнууд дараах арга хэмжээг авах ёстой:

- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хамгаалах зорилготой арга хэмжээ нь хүний бусад эрхийг зөрчихгүй байхыг баталгаажуулах;
- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн хүний эрхийн зөрчлийг зөвтгөсөн хариу арга хэмжээнээс зайлсхийх;
- Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааны үр дагаврын талаар

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИВ УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТҮЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ ХУРААНГУЙ

Эмнести Интернэшнл

мэдээлэл авах эрхийг баталгаажуулах, шийдвэр гаргах үйл явцад оролцох, мөн асуудлыг анхааралдаа авах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд үр дүнтэй арга хэмжээгээр хангах;

- Дасан зохицох чадвартай, нүүрстөрөгчийн хийгүй нийгэмд шилжих нь ядуурлыг бууруулах болон хүний эрхээ эдлүүлэхэд учирч байгаа тэнцвэргүй байдлыг засах боломжтойг баталгаажуулах;
- Уур амьсгалын өөрчлөлт, нүүрстөрөгчгүй эдийн засаг руу шилжих процесс шударга байж, үүнд өртөх бүх ажилчин, нийгмийн бүлэг хамгаалагдсан байхыг баталгаажуулах;
- Илүү дасан зохицох чадвартай, нүүрстөрөгчгүй нийгэмд шилжихдээ ирээдүй хойчийн эрхэд нийцүүлэхийг баталгаажуулах;
- Уур амьсгалын бодлого болон арга хэмжээг хүний эрхтэй уялдуулах.

ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ, ОРОЛЦОХ, ШҮҮХЭЭР ХАМГААЛУУЛАХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

Улс орнууд уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшгаас иргэдээ хамгаалах талаар тодорхой хэдэн зарчмын үүрэг хүлээдэг. Үүнд: мэдээлэл авах, олон нийтийн оролцоог дэмжих, хөндөгдсөн эрхээ хамгаалуулах, нөхөн сэргээлгэх шударга боломжийг бүрдүүлэх зэрэг орно. Байгаль орчныг хамгаалах асуудлаар хариуцлага тооцох, шаардлагатай арга хэмжээ авахыг шаардсан байгаль орчны хүний эрх хамгаалагчдын гүйцэтгэх чухал үүргийг хүлээн зөвшөөрөх, тэднийг үүргээ аюулгүй, бодитойгоор хэрэгжүүлэхэд шаардлагатай урьдач нөхцөлүүдийг бүрдүүлэх зэрэг орно.

Тодруулбал, улс орнууд дараах зүйлсийг хийх ёстой:

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдээллийг эрж хайх, шинэчлэх, түгээх, байгаль орчинтой холбоотой мэдээлэл авах боломжтой байх, хүүхдүүдэд хүрээлэн буй орчны боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар бодлого, стратеги, үндэсний төлөвлөгөө гаргах, түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, өөрчлөлтөд дасан зохицох тодорхой төсөл, үйл ажиллагааг санаачлахдаа утга учиртай оролцоо бүхий олон нийтийн хэлэлцүүлэг хийх, ялангуяа уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой шийдвэрүүдэд хамгийн их өртөх хүмүүсийг ялгаварлан гадуурхалгүйгээр оролцуулах. Тухайлбал, улс орнууд уугуул иргэдэд нөлөөлж болзошгүй арга хэмжээ авахаасаа өмнө тэдэнтэй хамтран ажиллах, эрх ашгийг нь хүндэтгэх, мэдээлэл өгсний үндсэн дээр чөлөөтэй зөвшилцөлд хүрэх, мөн газар нутаг, эд хөрөнгийг нь зөвшилцөлгүйгээр хураасан тохиолдолд хохирлыг барагдуулах арга хэмжээ авах. Тодруулбал, улс орнууд уур амьсгалын хямралд их бага хэмжээгээр өртсөн хувь хүмүүс, нийгэмлэг, бүлгүүд болон иргэдийн олон нийтийн оролцоог дэмжих;
- Уур амьсгалын өөрчлөлт эсвэл уур амьсгалтай холбоотой арга хэмжээнээс үүдэн эрх нь зөрчигдсөн хүмүүсийн эрхийг сэргээх. Тухайлбал, улс орнууд уур амьсгалын өөрчлөлт, түүнийг бууруулах арга хэмжээнээс үүссэн хүний эрхийн тулгараад буй эсвэл урьдчилан тооцохуйц зөрчил, газар нутгийн харьяаллаас гадна хилийн чанад дахь хүмүүсийг хохироосон зэрэг өнгөрсөн болон одоогийн зөрчил, маргааны нэхэмжлэлийг хянан шийдвэрлэхэд захиргаа, шүүх, хууль тогтоох болон бусад зохих арга хэрэгслийг ялгаварлан гадуурхахгүй, цаг алдалгүй, хүртээмжтэй ашиглах боломжоор хангах. Түүнчлэн улс орнууд

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ ХУРААНГУЙ

Эмнести Интернэшнл

хохирогчдыг зохистойгоор олон талаар хамгаалахын тулд түр завсарлах, нөхөн сэргээлт хийх, нөхөн олговор олгох, мөн сэтгэл ханамжийн болон дахин ийм үйл явдал давтагдахгүй байх баталгаагаар хангах ёстой бөгөөд нөлөөнд өртсөн бүх хүн шүүхээр эрхээ хамгаалуулах болон шударга нөхөх олговор авах боломжийг бүрдүүлэх;

- Байгаль орчин хамгаалагчдыг хүний эрх хамгаалагчдын нэгэн адил авч үзэх, мөн 1998 онд харилцан зөвшилцлөөр батлагдсан НҮБ-ын Хүний Эрх Хамгаалагчдын Тунхаглалын дагуу хамгаалах;
- Хүн бүрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван замаар эвлэлдэн нэгдэх, иргэний үл захирагдахуй зэрэг эрх, эрх чөлөөг баталгаажуулах, байгаль орчин хамгаалагчдад халдаж буй бүлгийг үл тэвчих соёлыг бий болгох зэргээр тэр хүмүүсийн нутаг орондоо амьдрах, байгаль орчноо хамгаалуулах, үг хэлэх мөн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хөдөлгөөн өрнүүлэх эрхийг хамгаалах ёстой.

НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН ХҮМҮҮСИЙН ЭРХИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ, АЛДАГДАЛ, ХОХИРЛЫГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ

Уур амьсгалын хямрал дэлхий даяар ялангуяа, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс хамгаалагдаж чадаагүй хамгийн бага орлоготой, жижиг арлуудын, эх газрын үржил шимгүй хэсгийн эсвэл хөгжиж буй орнуудын хүмүүсийн эрхээ эдлэх байдалд ноцтой хохирол учруулж байна.

Дэлхий даяар уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, түүнд дасан зохицох үйл ажиллагаа эрс өссөн ч явц өнөөг хүртэл удаашралтай, он удаан жилээр хий ялгаруулж ирсэн, зарим нөлөөлөл үр дагавар хүмүүсийн чадавхаас хэтэрсэн нь тодорхой болсон. Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, түүнд дасан зохицох хүчин чармайлт нь хямралын өнөөгийн яаралтай нөхцөл байдалтай нийцэхгүй бол экспоненциаль (богино хугацаанд тасралтгүй өсөх) түвшний хурдаар өссөөр байх бөгөөд үүнийг ихэвчлэн “алдагдал, хохирол” гэж нэрлэдэг. Алдагдал, хохиролд тухайлбал, аж амьдрал, орлого, амь насаа алдах, эрүүл мэндийн доройтол, дэд бүтцийн эвдрэл, нүүлгэн шилжүүлэлтэд өртөх, өвөг дээдсийнхээ газар нутаг дээр үргэлжлүүлэн амьдарч чадахгүйд хүрэх, газар нутагтайгаа холбогдсон онцлог чанар, соёлын өвүүдийг хадгалан хамгаалах боломжгүй болох зэрэг асуудлыг багтаадаг.

Хөндөгдсөн эрхийг сэргээх үүрэг амлалтын хүрээнд бүх улс орон өөрийн газар нутаг дээрээ болон хилийн чанадад гаргасан хүний эрхийн зөрчлийн хохирол, алдагдалд хамтарсан хариуцлага хүлээх хэдий ч хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасах зохицох чиглэлээр байгаа бололцооныхоо хүрээнд арга хэмжээ авч чадахгүй байна.

Эмнести Интернэшнл нь улс орнуудыг хүний эрхийн өмнө хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарлан, гарч буй хохирол, үр дагаврыг арилгахыг уриалдаг.

Ялангуяа, улс орнууд нь дараах зүйлсийг хийх ёстой:

- Болзошгүй алдагдал, хохирлыг газар авахаас сэргийлж, эрсдэлийг бууруулах, түүнд дасан зохицох үйл ажиллагааг эрчимжүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүссэн хохирол, алдагдлыг ялангуяа, эдийн засгийн бус хохирлуудыг үнэлэхдээ хүний амьд явах, эрүүл байх, хоол хүнс, шаардлагад нийцсэн орон байраар хангагдах, боловсрол эзэмших, ажил

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ ХУРААНГУЙ

Эмнести Интернэшнл

эрхлэх, соёлын болон өөрөө шийдвэр гаргах зэрэг хүний ихэнх эрхээ эдлэхэд саад болж буй уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавруудыг авч үзэх;

- Хохирол, алдагдалд нөхөн төлбөр олгох зэргээр хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх, тэдгээрийг шийдвэрлэх арга хэрэгсэл, хүртээмжтэй нөөцөөр (санхүү, технологийн шилжилт болон техникийн зөвлөгөө зэрэг) хангах.

Ялангуяа, олон улсын хамтын ажиллагааны үүрэг, хүний эрхийн зөрчлийн үр дагаврыг арилгах хөндөгдсөн эрхийг сэргээх үүргийнхээ хүрээнд чинээлэг, аж үйлдвэржсэн орнууд уур амьсгалын хямралаас үүдсэн хохирлыг эрх нь зөрчигдсэн хөгжиж буй улс орны ард түмэнд нөхөн төлбөр олгож, санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэх ёстой. Үүнд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн хохирол, алдагдал хүлээж буй хөгжиж буй улс орнуудын ард түмнийг дэмжих нөхөн олговор олгоход нь зориулсан нэмэлт, шинэ санхүүжилт гаргах үйл ажиллагааг багтаадаг.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТУСЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Байгаль орчны хууль тогтоомжийн дагуу “Хамтын боловч ялгаатай үүрэг хариуцлага, тус тусын чадвар” гэсэн зарчим болон хүний эрхийн хуулиар олон улсын хамтын ажиллагааны үүргийн хүрээнд улс орнууд өөрсдийн хүчин чадал, боломжоороо уур амьсгалын өөрчлөлт үүсгэж буй шалтгааныг шийдвэрлэх технологио хуваалцах, санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлэх ёстой. Улс орон бүр уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй дээр өөрсдийн хариуцлагын хүрээнд чадавхдаа тааруулан ажиллах нь олон улсын эрх зүйн болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг шударга ёсны төлөөх үйлдэл юм. Уур амьсгалын өөрчлөлт гарахад бага нөлөөлсөн улс орнууд ч нөлөөллийг аль болох бууруулах, дасан зохицох зорилгод хүрэхийн төлөө уур амьсгалын хямралаас үүдсэн хохирол, алдагдлыг арилгахад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Ялангуяа, улс орнууд дараах зүйлсийг хийх ёстой:

- Дэлхийн дундаж температурыг 1.5°C хэмээс доош төвшинд барихыг хичээж, тодорхой хугацаанд нүүрстөрөгчгүй, уян хатан бөгөөд хурдтай, ирээдүйд чиглэсэн чингэхдээ хүний эрхэд нийцсэн шилжилтийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах. Тэдгээр улсаас уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг төлөвлөсөн зорилтууддаа дангаар хүрч чадахгүй, тусламж шаардлагатай орнуудад хэрэгцээтэй санхүүгийн нөөц, чадавх бэхжүүлэлт, технологийн шилжилт хийхэд нь тусалж, хүмүүсийг дасан зохицох, уур амьсгалын хямралаас үүссэн хохирлыг арилгахад дэмжлэг үзүүлэх.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨӨС ҮҮДЭН ШИЛЖИН НҮҮСЭН, НҮҮХ ЭРСДЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ НЬ

Уур амьсгалын хямрал аль хэдийн шилжилт хөдөлгөөн бий болгоод эхэлсэн. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас ойр ойрхон давтагдах гамшигт үзэгдлүүд бүхэл бүтэн улс орон, эсхүл тэдгээрийн зарим хэсгийг амьдрах орчингүй болгож, дотооддоо эсвэл улс хооронд хил дамнасан хүмүүсийн шилжилт хөдөлгөөнийг нэмэх хандлагатай байна.

Улс орнууд уур амьсгалын өөрчлөлт, гамшигийн хүрээнд шилжилт хөдөлгөөнтэй холбоотой бодлого, арга хэмжээг баталж, хэрэгжүүлэхдээ хүний эрхийн үүрэг хариуцлагаа дагах ёстой.

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!
ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХНИЙГ ХАМГААЛАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ
ХУРААНГУЙ

Тодруулбал, улс орнууд дараах зүйлсийг хийх ёстой:

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, түүний үр дагаварт дасан зохицоход ард иргэдийг дэмжих, гамшигт үзэгдлээс хүмүүсийг хамгаалах, дотооддоо болон олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хүний эрхийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор дотооддоо болон хил дамнах шилжилт хөдөлгөөний магадлал, цар хүрээг бууруулах, түүнчлэн Тогтвортой хөгжлийн зорилт, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн хөтөлбөр, Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлэх;

- Байнга хийгддэг дахин суурьшуулах нь цаг уурын өөрчлөлтийн зайлшгүй нөлөөллөөс хүмүүсийг хамгаалах эцсийн арга хэмжээ байж чадах эсэхийг баталгаажуулах (жишээлбэл: тухайн бүс нутагт хүн амьдрахад хэт аюултай болсон үед) нүүлгэн шилжүүлсэн болон оршин суугч иргэдийн аль алиных нь эрхийг хүндэтгэх, хамгаалах, мөн үүнийгээ нүүлгэн шилжүүлэлтийн явцад байнга биелүүлж байх;
- Олон улсын эрх зүйн дагуу дотооддоо нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн иргэдийн эрхийг хамгаалах өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, уг асуудлыг үндэсний хууль тогтоомж, бодлогодоо тусгах;
- Олон улсын эрх зүйн дагуу хүний эрх, түүний дотор хөдөлмөрийн эрхийг хүндэтгэх, сайжруулах мөн тэдгээрийг хэрэгжүүлдэг аюулгүй, тогтмол шилжилт хөдөлгөөний хэлбэрүүдийг нэмэгдүүлж, ажлын виз, боловсрол эсвэл гэр бүлийн зорилго бүхий виз олгох зэрэг шилжилт хийх нөхцөлийг өргөн хүрээнд бүрдүүлэх;
- Эрх баригчид олон улсын хамгаалалтад орох хүсэлтийг хүлээн авах, шийдэхдээ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн хүний эрх зөрчигдөх эрсдэлийг тооцоолж, дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр арга хэмжээ авах ёстой. Засгийн газраас уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавраас хүний эрх зөрчигдөх бодит эрсдэлтэй газарт хүмүүсийг шилжүүлэх ёсгүй;
- Хүн бүрийг ялангуяа цагаач, дүрвэгч, орогнол хүсэгчид дотооддоо нүүн шилжсэн болон хямралд хамгийн их нэрвэгдсэн хүмүүсийг уур амьсгалын өөрчлөлт ба шилжилт хөдөлгөөнтэй холбоотой үндэсний, бүс нутгийн болон олон улсын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулах, мөн тэднийг үр дүнтэй мэдээллээр хангах;
- Дүрвэгсдийн тухай олон улсын гэрээ, Цагаачлалын тухай олон улсын гэрээ, нүүлгэн шилжүүлэх асуудлаарх НҮБ/УАӨСК-(Нэгдсэн үндэсний байгууллагын уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц)-ын ажлын хэсгийн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;
- Уур амьсгалын өөрчилтөд өртөмтгий хөгжиж буй орнуудын уур амьсгалын хямралаас үүдэн алдагдал, хохирол хүлээж, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн эсвэл өртөж болзошгүй олон нийт тэр дундаа уугуул иргэд болон нийгмийн бүлгүүдэд нөхөн олговор олгох зохицуулалт, дэмжлэг үзүүлэх, нөхөн сэргээх арга хэрэгслийг бий болгох зохистой тогтолцоог баталж, санхүүжилтийг дайчлан төвлөрүүлэхэд хамтран ажиллах хэрэгтэй.

Тодруулбал, уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их хариуцлага хүлээх улс орнууд дараах зүйлсийг хийх ёстой:

- Учруулсан хохирлын хувь хэмжээгээрээ нөлөөлөлд өртсөн хүмүүсийн эрхийг сэргээхэд хамтын хариуцлага хүлээхээ ухамсарлах, үүнд: алдагдал, хохирлыг барагдуулах олон улсын тогтолцоог дэмжих уур амьсгалын санхүүжилтэд хувь тэгш байж, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс болж эх орондоо буцаж

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТҮЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ ХУРААНГУЙ

Эмнести Интернэшнл

очиж чадахгүй дүрвэсэн хүмүүсийг нутаг дэвсгэртээ хүлээн авах тодорхой хамгаалалтын тогтолцоог бий болгох зэрэг орох;

- Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас улс орондоо амьдрах боломжгүй болж, шилжин суурьших шаардлагатай болсон хүмүүст дэмжлэг үзүүлэхэд хамтран ажиллах. Улс орнууд нөлөөлөлд өртсөн хүмүүст бодитоор зөвлөлдөх, бие даан шийдвэр гаргах, өөрсдийгөө тодорхойлох, хамтын үнэт зүйлээ хадгалах, дахин төвхнөх нөхцөлийг нь бүрдүүлэх.

АЮУЛГҮЙ, ЦЭВЭР, ЭРҮҮЛ ТОГТВОРТОЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ НЬ

Дэлхий даяар, аюулгүй, цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрхийг анхаарч байна. Одоогоор 110 орон Үндсэн хуульдаа эдгээр эрхийг оруулсан. Энэхүү эрх нь бүс нутгийн түвшинд хүний эрхийн баримт бичигт тусгагдсан байдаг. Хүний эрх, хүрээлэн буй орчны асуудлаарх НҮБ-ын Тусгай Илтгэгчийн дурдсанаар НҮБ-ын гишүүн 193 улсаас 156 нь энэ эрхийг Үндсэн хуульдаа тусгасан бөгөөд энэ талаар тусгасан бүс нутгийнхаа гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон байдаг.

Тийм хэдий ч НҮБ энэхүү эрхийг одоог хүртэл шууд хүлээн зөвшөөрөөгүй байна. НҮБ-ын эрүүл, цэвэр, аюулгүй бөгөөд тогтвортой орчинд амьдрах эрхийн тухай тогтоол нь энэхүү эрхийг хүний эрхийн бусад зарчимтай ижил төвшинд тавих, эрүүл орчин, түүний дотор уур амьсгалын аюулгүй байдлыг нэр төртэй, аюулгүй, амьдрахад зайлшгүй шаардлагатай гэж авч үзсэнээр хүн бүрийн ирээдүй хойчийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг илүү тодотгож өгсөн. Ингэснээр улс орнуудын байгаль орчны бодлого, хууль тогтоомж сайжирч, дэмжлэг үзүүлэх эрх зүйн үндэс суурийг бэхжүүлэн, улмаар байгаль орчны нөхцөл байдлыг сайжруулна. Мөн байгаль орчин хамгаалагчдын хөдөлмөрийг үнэлэх үнэлэмжийг дээшлүүлж, Засгийн газар болон корпорациудад хүний эрхийн зөрчил, хууль, дүрмийн зөрчил, байгаль орчинд учруулсан хор уршигт хариуцлага хүлээлгэх хүчтэй хэрэгсэл болох юм.

Тодруулбал, улс орнууд нь дараах зүйлсийг хийх хэрэгтэй:

- Эрүүл, цэвэр, аюулгүй бөгөөд тогтвортой орчинд амьдрах эрхийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх үндэсний хууль тогтоомжийг баталж хэрэгжүүлэх;
- Тус эрхийг НҮБ-аар хүлээн зөвшөөрүүлэхийг дэмжих.

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ НЬ

Олон улсын эрх зүйн дагуу улс орнууд бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн хохирлоос, тэр дундаа бизнесийн байгууллагын уур амьсгалын өөрчлөлтөд оруулсан хувь нэмрээс үүдэн гарах хохирлоос дүрэм журам, хяналт, мөрдөн байцаалт, маргаан таслан шүүх, шийтгэл хүлээлгэх замаар бүх хүнийг хамгаалах үүрэгтэй.

Улс, орнууд өөрсдийн нутаг дэвсгэртээ эсвэл шүүн таслах харьяаллынхаа хүрээнд корпорациудын үйл ажиллагааг хянах буюу түүнд нөлөөлөх боломжтой нөхцөлд тэдгээр бизнесийг олон улсын үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэх нөхцөлийг бүрдүүлэх мөн тэднээс шалтгаалсан хохирлыг арилгах үр дүнтэй зохицуулалт хийх ёстой.

Тодруулбал, улс орнууд нь дараах зүйлийг хийх ёстой:

- Уур Амьсгалын Өөрчлөлтийн асуудлаарх Засгийн Газар хоорондын Мэргэжилтнүүдийн хороо (УАӨАЗГХМХ)-ны зөвлөмжийн дагуу хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2030 онд 2010 оныхоос багадаа 45% -иар бууруулж, 2050 оноос өмнө энэ үзүүлэлтийг тэглэснээр бизнес эрхлэгчид үйл ажиллагаа болон өртгийн сүлжээнийхээ хүрээнд ялгаруулалтыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэх тогтоомж, бодлогын арга хэмжээг батлах;
- Олон улсын үйл ажиллагаа, өртгийн сүлжээ болон бизнесийн харилцаандаа санхүү, бизнесийн төрлийн бүх корпорациуд хүний эрхийг хүндлэх мөн хүний эрхийн болон байгаль орчны зохих хяналт хийх, хариуцлага хүлээх хуулийг батлах, мөрдүүлэх;
- Санхүү, бизнесийн корпорациудыг зохих бодлого болон түүний хэрэгжилт, нөлөөллийн үнэлгээ, нөлөөлөлд өртөж болзошгүй болон бодитоор өртсөн өмчлөгчидтэй харилцах харилцаа, зөвлөлдөх уулзалтууд болон эдгээр нөлөөлөл, эрсдэлүүдийг бууруулах арга хэмжээнүүдийнхээ тухай тогтмол бөгөөд ил тодоор тайлагнахыг шаардах;
- Корпорацийн байгаль орчны болон хүний эрхийн эрсдэлүүдийн хяналт нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бүхнийг багтаах ёстой;
- Төв банк гэх мэт санхүүгийн удирдагч байгууллагууд 1.5°C хэмийн хязгаарт санхүүгийн салбарын нийцэх байдлыг хурдасгах удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх. Жишээлбэл, энэ нь төв банкны стресс тестийн хүрээнд уур амьсгалын хэтийн төлөвийг багтаах шаардлага, уур амьсгалын эрсдэлийг илрүүлэхийг зайлшгүй болгох болон малтмал түлшний зээлд өндөр нөхцөл тавьдаг хөрөнгийн өөрчлөлт оруулах зэрэг орно;
- Уур амьсгалтай холбоотой бодлого боловсруулах, хүний эрх, байгаль орчны зохих шаардлагыг хэрэгжүүлж малтмал түлш, хөдөө аж ахуйн бизнес болон их хэмжээний хүлэмжийн хий ялгаруулдаг бусад корпорациудын сөрөг нөлөөнөөс хүмүүсийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх;
- Корпорациудын уур амьсгалд үзүүлж буй нөлөө түүнд үзүүлэх хариу арга хэмжээнээс үүссэн хүний эрхийн зөрчлөөс үүдэн хохирсон хүмүүс үр дүнтэй арга хэрэгслийг ашиглахад шүүх, гүйцэтгэх, хууль тогтоох эсвэл бусад боломжит аргаар тохирсон алхмуудыг хийх.

КОРПОРАЦИУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд нь бизнес эрхлэгчдэд хүний эрхийг дээдлэх бие даасан үүрэг хариуцлагыг тогтоодог. Корпорациудын хүний эрхийн үүрэг хариуцлага нь уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлж буй өөрсдийн үйл ажиллагааныхаа хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах, хариуцлага хүлээх зэрэг өргөн хүрээг хамарна. Дотоодын хууль тогтоомжоор уур амьсгалын өөрчлөлтийг тодорхой зохицуулаагүй тохиолдолд ч тус үүрэг хариуцлага нь мөрдөгдөнө.

Эмнести Интернэшнл нь корпорациудыг уур амьсгалын өөрчлөлтийн асуудлын хүрээнд хүний эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлж, үйл ажиллагаа болон бизнесийн загваруудаа Парисын хэлэлцээрийн зорилтуудад нийцүүлэх, ялангуяа дэлхийн дундаж температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үеийнхээс дээшлүүлэхгүй 1.5°C хэмд хязгаарлах амлалтдаа хүрэхийг уриалдаг.

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТҮЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ ХУРААНГУЙ

Эмнести Интернэшнл

Корпорациуд үүргээ биелүүлэхийн тулд дараах зүйлийг хийх ёстой:

- Өөрсдийн болон охин компани, ханган нийлүүлэгчдийнхээ үйл ажиллагаанд байгаль орчны болон хүний эрхийн олон улсын стандартыг дагаж мөрдөх нөхцөл бүрдүүлэх;
- Уур Амьсгалын Өөрчлөлтийн асуудлаарх Засгийн Газар хоорондын Мэргэжилтнүүдийн хороо (УАӨАЗГХМХ)-ны зөвлөмжийн дагуу үйл ажиллагаа, өртгийн сүлжээндээ хүлэмжийн хийн ялгарлыг аль болох хурдан бууруулах, 2030 он гэхэд 2010 оныхтой харьцуулахад хамгийн багадаа 45%-иар бууруулах, 2050 оноос өмнө тэг төвшинд хүргэх тодорхой төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх. Нөхөн төлбөр олголт, нүүрстөрөгчийн ялгаруулалтыг арилгах арга хэрэгсэлд хэт найдалгүй эдгээр үүрэг амлалтуудаа ажил хэрэг болгохын тулд үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх хэрэгтэй. Ялангуяа эрчим хүч үйлдвэрлэгчид, ханган нийлүүлэгчид бүтээгдэхүүний төрлөө хүний эрхэд нийцсэн байдлаар үйлдвэрлэдэг болох. Энэ нь сэргээгдэх эрчим хүчийг ашиглах замаар малтмал түлшний олборлолт, хэрэглээг яаралтай зогсоох хэрэгтэй гэсэн үг;
- Банк, хөрөнгийн менежер, даатгалын компаниуд гэх мэт санхүүгийн байгууллагууд малтмал түлшний тэлэлт, ой модгүйжүүлэлт үүсгэдэг шинэ төсөл, үйл ажиллагаа, үйлдвэрүүдэд санхүү, хөрөнгө оруулалт хийхээ зогсоох. Мөн 1.5°C хэмд барих үүргийнхээ дагуу одоогийн санхүү, хөрөнгө оруулалтаа зогсоох ёстой бөгөөд нүүрс, хүлэр, хий, өрөмдлөг, битум хар тос зэрэг хамгийн их бохирдол үүсгэдэг малтмал түлш болон түүний үйлдвэрлэлд олгох санхүүжилт, хөрөнгө оруулалтыг чинээлэг аж үйлдвэржсэн орнуудад хамгийн холдоо 2030 он, бүх улс оронд 2040 онд хариуцлагатайгаар зогсоох;
- Хүний эрх болон байгаль орчны хяналтыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагынхаа дагуу компаниуд олон улсын хэмжээнд явуулж буй үйл ажиллагааныхаа хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, бууруулах, түүндээ хариуцлага хүлээх ёстой. Тэд өөрсдийн хүлэмжийн хийн ялгаруулж буй байдал, түүний нөлөөллийг бууруулах ажлынхаа талаар холбогдох мэдээллүүдийг бүх охин компани, салбар болон хангамжийн сүлжээгээрээ дамжуулан олон нийтэд мэдээлвэл зохино;
- Дахин сэргээгдэх эрчим хүчний болон холбогдох технологийн үйлдвэрлэлтэй холбоотой уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох үйл ажиллагаанд оролцохоор төлөвлөхдөө компаниуд зохих шалгалтын үйл явцын бүх үе шатанд нөлөөлөлд өртсөн мөн өртөж болзошгүй эрх эдлэгчидтэй үр дүнтэй, бодитой, мэдээллээр хангасны үндсэн дээр зөвлөлдөх уулзалт хийх ёстой. Бизнес эрхлэгчид уур амьсгалын өөрчлөлтийг бий болгоход оруулсан үр нөлөө, улмаар хүний эрхийн хохирлынхоо төлөө хариуцлага хүлээх ёстой бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийн хохирлыг барагдуулах алхмууд хийх ёстой;
- Нүүрсэнд суурилсан эдийн засгийг үргэлжлүүлэх бодлого, шийдвэрүүдэд зориулан худалдааны холбоогоор дамжуулан шууд болон дам аль ч хэлбэрээр Засгийн газруудыг лоббидохоос татгалзах. Түүнчлэн олон нийтийг үнэн зөв мэдээлэл олж авах, үндэслэлтэй шийдвэр гаргахад түвэг учруулдаг худал, төөрөгдүүлсэн, үндэслэлгүй мэдээлэл түгээх кампанит ажлуудыг дэмжихээс татгалзах хэрэгтэй.

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

**ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ
ХУРААНГУЙ**

Эмнести Интернэшнл

**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ НЬ
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨХ ДАЯН
ДЭЛХИЙН ХӨДӨЛГӨӨН БӨГӨӨД
НЭГ ХҮНД ТОХИОЛДОХ ШУДАРГА
БУС ЯВДАЛ Ч БИД БҮГДЭД
ХАМААРАХ АСУУДАЛ ЮМ.**

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

Холбоо барих



info@amnesty.org
mongolia.amnesty@gmail.com



+44 (0)20 7413 5500
+976 7000 4708



www.facebook.com/AmnestyGlobal
[www.facebook.com/Amnesty International](http://www.facebook.com/AmnestyInternational)
Mongolia - Монголын Эмнести Интернэшнл



@AmnestyOnline

БИДНИЙ ЭРХИЙГ БҮҮ ТҮЙМЭРД!

ЗАСГИЙН ГАЗАР, КОРПОРАЦИУД УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛААС ХҮН ТӨРӨЛХТНИЙГ ХАМГААЛАХЫН ТҮЛД ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ.

ХУРААНГУЙ

Уур амьсгалын аюул хүний эрхийн хямралын шалтгаан болж байна. Энэ нь аль хэдийн олон сая хүний амьдралыг сүйрүүлэн, тэгш бус байдал, ялгаварлан гадуурхлыг даамжруулж, бидний ихэнх эрхээ эдлэхэд төдийгүй хүн төрөлхтний ирээдүйд заналхийлж байна.

Улс орнуудын уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх оролдлого нь хүн төрөлхтөн, манай гарагт хамгийн их хохирол учруулж буй нөлөөллөөс зайлсхийхэд шаардагдах тэр хэмжээний хаана ч хүрэхгүй байна.

Чинээлэг аж үйлдвэржсэн орнуудын дийлэнх нь олон улсын эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ үл хайхран хийн ялгарлыг богино хугацаанд бууруулж, хөгжиж буй орнуудад нүүрстөрөгчийн ялгаралгүй эдийн засаг, дасан зохицох чадвартай нийгмийг бий болгоход зориулах хангалттай санхүүжилт гаргахгүй байна.

Улс орнууд малтмал түлшийг хэрэглээнээс гаргах, иргэдээ уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, уур амьсгалтай холбоотой нөлөөллөөс шалтгаалсан алдагдал, хохирлыг арилгах арга хэрэгслээр хангах зэргээр нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ авч чадаагүй бол энэ нь хүний эрхийг зөрчиж байгаа хэрэг юм.

Байгаль орчинд хөнөөл учруулж буй хорт хийн ялгаруулалт болон бусад үйл ажиллагааг эрс бууруулж чадахгүй байх нь бизнес эрхлэгчид хүний эрхийг зөрчиж байгаа үйлдэл юм.

Энэхүү товхимолд уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах; улс орнуудын болон корпорациудын хүлээсэн үүрэг хариуцлагыг тусгасан бөгөөд нийгэм, эдийн засгийг малтмал түлш, нүүрснээс ангижруулах ажлыг шуурхай бөгөөд шударгаар явуулахад хүний эрх ямар чухал болохыг тусгасан болно.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

INDEX: POL 30/4110/2021 JUNE 2021
LANGUAGE: ENGLISH [amnesty.org](https://www.amnesty.org)
ИНДЕКС: POL 30/4110/2021 ЗУРГАДУГААР
CAP 2021 ХЭЛ: АНГЛИ
[amnesty.org](https://www.amnesty.org)

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ

